

□

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

ЦАХИМ БОДЛОГЫН ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн алба, үйлчилгээг шуурхай, ил тод, хэмнэлттэй болгох, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийг сайжруулах, иргэний мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон түүний хувийн мэдээллийн өгөгдлийн нууцыг хамгаалах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний мэдээллийн дэд бүтцийг хамгаалах чадавх бий болгох, энэ чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, цахим бодлогын асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Цахим бодлогын түр хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- 1/ Ж.Батзандан Улсын Их Хурлын гишүүн
- 2/ Б.Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн
- 3/ Л.Болд Улсын Их Хурлын гишүүн
- 4/С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн
- 5/Ж.Мөнхбат Улсын Их Хурлын гишүүн
- 6/Н.Оюундарь Улсын Их Хурлын гишүүн
- 7/Д.Оюунхорол Улсын Их Хурлын гишүүн
- 8/М.Оюунчимэг Улсын Их Хурлын гишүүн
- 9/Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын гишүүн
- 10/О.Содбилэг Улсын Их Хурлын гишүүн
- 11/Б.Ундармаа Улсын Их Хурлын гишүүн
- 12/А.Ундраа Улсын Их Хурлын гишүүн
- 13/Н.Учрал Улсын Их Хурлын гишүүн
- 14/Л.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн
- 15/Ж.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн

[/Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 50 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./](#)

2.Энэ тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД